



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 07 өдөр

Дугаар А/632

Номгон

Эзэмшил газрын зориулалтыг
өөрчлөх тухай

“Газрын тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. Иргэн М.Цогтын хүсэлтийг харгалзан Баянхонгор сумын Рашаант 10-р баг Таван-Эрдэнийн гудамж-1, 106а тоот хаягт байрлах 6409009697 нэгж талбарын дугаар бүхий Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай 560 м2 газрын зориулалтыг 4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц болгон өөрчилсүгэй.

2. Зориулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

3. Эзэмшил газрын 10 хувийг цэцэрлэгжүүлэн зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг иргэдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210477

Аймгийн Засаг даргын 2017 оны 11 дугаар сарын 07
-ний өдрийн 10 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨГДӨЖ
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регситрийн дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Өөрчлөгдөж байгаа зориулалт
1	М.Цогт	ВЭ64090774	Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Таван-Эрдэнийн гудамж-1, 106а тоот	560 м2	4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц

.....оОо.....